



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 37

Улаанбаатар хот

Мэргэшил олгох тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.23, Эрүүл мэндийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 491/A472 дугаар хамтарсан тушаалын “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”-ын 2.16-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхдийн эмчийн түргэвчилсэн сургалтанд Эрүүл мэнд, спортын яамны захиалгаар 2014-2015 оны хичээлийн жилд элсэн, хөтөлбөрийн дагуу суралцаж, төгсөлтийн улсын шалгалтад тэнцсэн (24) их эмчийн нэрс, мэргэшил, үнэмлэхийн дугаарыг хавсралтаар баталсугай.

2. Хүүхдийн эмнэлэг ашиглалтад орох хүртэл суралцагчдын харьяалагдах Эрүүл мэндийн газартай зөвшилцөн, тухайн орон нутгийн шаардлагатай эрүүл мэндийн байгууллагад мэргэшлээр нь ажиллуулах, хүүхдийн эмнэлэг ашиглалтад орсны дараа уг эмнэлэгт татаж ажиллуулж төгсөгчдийн мэргэшлийн үнэмлэхийг харьяалах эрүүл мэндийн байгууллагад хүлээлгэн өгөхийг Эрүүл мэндийн хөгжлийн төв (Ч.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн дарга /С.Ламбаа/-д даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080124